



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 06 сар 03 өдөр

№ 05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 61.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйл, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 72 дугаар зүйл болон Хөсөг трейд ХК (цаашид “Компани” гэх)-ийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 05 сарын 19-ний өдрийн №9/1941 тоот албан бичиг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 06 сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 07 сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сэнтрал тауэр 902 тоот хурлын танхимд зохион байгуулж дор дурдсан асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1.1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах /ердийн санал хураалт/;

1.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох /кумулятив аргаар/;

1.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох /кумулятив аргаар/;

2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 06 сарын 25-ны өдрөөр тогтоосугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тухай зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан 2026 оны 06 сарын 08-ны өдөр нийтэд мэдээлэх ба уг зарыг 2026 оны 06 сарын 23-ны өдөр дахин нийтэд мэдээлэхийг сануулсугай.

4. Ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцах материалын жагсаалтыг Хавсралт 01-ээр баталж, энэхүү баримт бичгийг 2026 оны 06 сарын 10-ны өдөр брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

5. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 02, 03-т зааснаар тус тус баталсугай.

6. Компанийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах хугацааг 2026 оны 06 сарын 25-ны өдрийн 10:00 цагаас 2026 оны 07 сарын 09-ний өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.

7. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах болон тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | |
|--------------|---------------------------------------|
| • С.Болор | Хурлын дарга |
| • Б.Анхбаяр | Хурал зохион байгуулах комиссын дарга |
| • Б.Гэрэлмаа | Тооллогын комиссын дарга |
| • Л.Сүрэн | Гишүүн |

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс-д даалгасугай.

11. Хурлын зарын загварыг Хавсралт 04-өөр, хурлын дэгийг Хавсралт 05-аар тус тус баталсугай.

12. Хурлын зар өгөх, хурал зохион байгуулах зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга (Б.Анхбаяр)-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.

13. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор Хавсралт 06-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга (Б.Анхбаяр)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.БОЛОР



**“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД
ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.

- Компанийн ээлжит бус хурал зарласан тухай гаргасан шийдвэр;
- Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл;
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн мэдээлэл;
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудасны загварууд;



**“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 07 сарын 16-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сентрал тауэр 902 тоот хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд / овогтой

Төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар:

Регистрийн дугаар:

Гэрийн хаяг:

Эзэмшиж буй хувьцааны төрөл:

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Кумулятив аргаар өгөх саналын тоо:

Бүртгэсэн: /Үнэт цаасны компанийн нэр/

Брокерын овог Нэр

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1		
2		
3		
4		
5		
6		
№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1		
2		
3		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг..... /

Санал авахыг хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга /

Гишүүн..... /

Шалгаж хүлээн авсан БДК-ийн ажилтан..... /

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Засварласан, балласан, залруулгатай санал авах хуудсыг нь хүчингүйд тооцогдоно.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох санал өгөхдөө кумулятив аргыг ашиглана. Энэ аргаар саналаа өгөхдөө эзэмшиж буй хувьцааныхаа тоог 6-аар үржүүлж гарсан тоог ердийн гишүүдэд нэр дэвшиж буй 6 хүнд дурын харьцаагаар хувааж өгнө. Харин хувьцааныхаа тоог 3-аар үржүүлж гарсан саналын тоог хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 3 хүнд дурын харьцаагаар хувааж саналаа өгнө. Тухайлбал, таны эзэмшиж буй хувьцааны тоо 100 гэвэл 600 саналын ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүнээс нэг хүнд бүгдийг нь өгч болно, эсвэл нэгэнд нь 500 саналаа 2 дахь нь 100 саналаа гэх мэтээр ямар ч харьцаагаар хувааж өгч болно. 300 саналаа хараат бус гишүүд нэр дэвшиж буй нэг хүнд бүгдийг нь эсвэл 3 хүнд адилхан 100 саналаа өгөх мэтээр хувааж өгнө. Гэхдээ хараат бус гишүүнд нийт саналынхаа 1/3-ыг ердийн гишүүдэд нийт саналынхаа 2/3-ыг өгсөн байх ёстой.

**“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**



“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 07 сарын 16-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сентрал тауэр 902 тоот хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд / овогтой

Төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар:

Регистрийн дугаар:

Гэрийн хаяг:

Эзэмшиж буй хувьцааны төрөл:

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Кумулятив аргаар өгөх саналын тоо:

Бүртгэсэн:/Үнэт цаасны компанийн нэр/

Брокерын овог Нэр

№	Хурлаас гарах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн шинэчилсэн дүрэм батлах			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг..... /

Санал авахыг хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга/

Гишүүн...../

Шалгаж хүлээн авсан БДК-ийн ажилтан..... /

**“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**



“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 07 сарын 16-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Централ тауэр 902 тоот хурлын танхимд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 06 сарын 25-ны өдөр.

Компанийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах хугацаа: 2026 оны 06 сарын 25-ны өдрийн 10:00 цагаас 2026 оны 07 сарын 09-ний өдрийн 16:00 цаг хүртэл

Санал хураалтын хуудас хүлээн авах газар: Өөрийн үйлчлүүлдэг брокерын газар эсхүл [husugtrade@gmail.com-aap](mailto:husugtrade@gmail.com) хүлээн авна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох;

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг Брокер, дилерийн компани дээр 2026 оны 06 сарын 11-ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд (Даваа-Баасан) 09:00 цагаас 16:00 цаг хүртэл авах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Анхбаяр болон гишүүдтэй холбоо барих, мэдээлэл авах утас: 99029407, 88031871

Имэйл хаяг: husugtrade@gmail.com

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

**“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ**



Хурал 2026 оны 07 сарын 16-ны өдрийн 10:00 цагт эхэлнэ.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах этгээд
1	Хурлын ирцийг бүртгэх	10:00-10:05	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг хурлын дарга болон хуралд оролцогч нарт мэдээлэх	10:05-10:10	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	10:10-10:20	Хурлын дарга
4	Компанийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийг танилцуулах	10:20-10:30	Хурлын дарга
5	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг танилцуулах	10:30-10:50	Хурлын дарга
6	Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт	10:50-11:10	Хурлын дарга
7	Саналын хуудас бөглөх заавар танилцуулах	11:10-11:20	Тооллогын комисс
8	Саналын хуудсаар санал авах	11:20-11:40	Тооллогын комисс
9	Санал хураалтын дүнг танилцуулах	11:40-11:45	Тооллогын комисс
10	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	11:45-11:50	Хурлын дарга
11	Хурлыг хаах	11:50-11:55	Хурлын дарга